

Монгол Улс
НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд Өмнөговь аймгийн хувийн хэвшлийн
байгууллагуудтай хийсэн зөвлөлдөх уулзалт
2017 оны 9-р сарын 14

Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл ibaatarkhuu@worldbank.org и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.

Дэлхийн Банк Групп нь (ДБГ) Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлоо солилцох зорилгоор 2017 оны 9 дугаар сарын 14-нд хувийн хэвшлийн 9 төлөөлөлтэй уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

1. Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
2. Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
3. Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
<p style="text-align: center;">Дүн шинжилгээний баримт бичигт тусгах санал (боломж, сорилт, тулгамдсан асуудал ба ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга замууд)</p>	<p><u>Сорилтууд:</u></p> <p><u>Бизнесийн орчин:</u></p> <ul style="list-style-type: none"> • ЖДҮ-д үзүүлдэг дэмжлэг хангалтгүй, зээл авах боломж хязгаарлагдмал, барьцаа хөрөнгийн үнэлгээ бага байдаг • Банкнаас ЖДҮ-т зориулсан зээлийн хэмжээ нь бизнес эхлэхэд хангалтгүй байдаг (жишээ нь, арилжааны банкны 20-30 сая төгрөгийн зээлийн хязгаарлалт нь бизнес эхлэхэд хангалтгүй, үүнээс их хэмжээний зээлийн шийдвэрийг яам гаргадаг боловч орон нутгийн эрэлт хэрэгцээ, ямар бизнес цаашид орон нутагт хөгжих боломжтой талаар тэд сайн мэддэггүй) • Зээлийн шалгуур, шаардлага хэт өндөр, банкны хүү маш өндөр байна. • Аж ахуйн нэгжүүдэд татварын их дарамт байдаг • ЖДҮ-ийн чадавх дутмаг байдаг. Иймд ЖДҮ-т зориулсан сургалт, суралцах боломжийг олгох шаардлагатай. • Орон нутгийн ЖДҮ-үүд бүтээгдэхүүнээ Оюу Толгой зэрэг томоохон уурхайд нийлүүлэх боломж хязгаарлагдмал байдаг. Учир нь ийм томоохон уурхайн шаардлага хэт өндөр байдаг (орон нутгийн бизнес эрхлэгчид зөвхөн савласан ус, ариун цэврийн цаасыг л ОТ-д нийлүүлж чадаж байна) • Хөдөө аж ахуйн салбар хөгжөөгүй, техник тоног төхөөрөмж нь хуучирсан. <p>Говийн бүсийн байгаль орчны асуудлууд:</p> <ul style="list-style-type: none"> • Говийн бүсэд цөлжилт нэмэгдэж байна • Усны нөөц улам багасч байна (жишээ нь, Ханбогд суманд) • Уур амьсгалын өөрчлөлт нь бүс нутагт нөлөөлж байна • Хятадын хилийн ойролцоо байрладаг салхин сэнс нь борооны үүлийг хөөдөг учраас говийн уур амьсгалд сөргөөр нөлөөлж байна гэлцдэг. <p>Засаглал, төрийн алба:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн бүх түвшинд бодлогын тууштай уялдаа холбоо, зохицуулалт дутмаг • Улс төрийн сонгуулийн мөчлөг дагасан төрийн албаны тогтворгүй байдал нь төрийн албаны чадавхийг сулруулж байна.

- Төрийн алба болон төрөөс санхүүжүүлж буй төслүүдийн хяналт сул. Төрийн алба авилгал ихтэй, хариуцлагын тогтолцоо сул, төрийн албанд улс төрийн хөндлөнгийн оролцоо маш их.
- Урт хугацааны бодлого төлөвлөлт хийх чадавхигүй, ийм тогтолцоо байхгүй.

Бусад:

- Суралцах боломж хязгаарлагдмал, орон нутгийн бизнес эрхлэгчид чадавх муутай, хоцрогдсон арга барил, технологи ашигласаар байна.
- Хөгжлийн байгууллагуудын дэмжлэг тусламж, санхүүжилт нь хүнд суртлын улмаас зорилтот үр өгөөж хүртэгчдэд хүрдэггүй.
- Уул уурхайн бус салбарууд хөгжөөгүй, эдийн засгийг төрөлжүүлээгүй учраас өсөлт, уналтын мөчлөгийг даган эдийн засаг тогтмол хэлбэлздэг
- Банк, санхүүгийн салбарын эмзэг байдал нэмэгдсэн, тус салбарын засаглал сул.
- Боловсролын чанар, хамрах хүрээг сайжруулахад чиглэсэн хүртээмжтэй өсөлт дутмаг.

Хамтран ажиллах боломж, чиглэлүүд:

- Мал аж ахуй / ХАА-н салбарыг хөгжүүлэх боломж их бий. Бэлчээрийн усалгааны аргуудыг судлах хэрэгтэй. Ажлын байр ихээр бий болгохын тулд хөдөө аж ахуй, мал аж ахуйд тулгуурласан хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай. Эдийн засгийг төрөлжүүлэхийн тулд малын гаралтай бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг дэмжих боломжийг судлах хэрэгтэй.
- Байгалийн нөөцийн менежмент, уул уурхайн салбараас улсын төсөвт төвлөрч буй орлогын удирдлагыг сайжруулах хэрэгтэй
- Байгаль орчныг хамгаалах: Бэлчээр, усны менежментийг сайжруулах шаардлагатай; уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх; байгалийн нөөцийн (тэр дундаа усны) менежментийг сайжруулах
- Орон нутгийн ЖДҮ-т санхүүжилт олгох замаар хувийн хэвшлийг дэмжих, уул уурхайн үйл ажиллагаанд бүтээгдэхүүн нийлүүлэх боломжийг олгох, дэмжих, Өмнөговь аймагт орон нутгийн бизнес эрхлэгчид, иргэдтэй хамтран ажиллаж ОТ-д бүтээгдэхүүн үйлчилгээ нийлүүлэх нийлүүлэлтийн гинжин хэлхээ бий болгох; экспортын хөгжүүлэх чиглэлээр сургалт явуулах (ДБ-ны төслийн сургалтууд амжилттай болсон)
- Банкны салбар: ЖДҮ-т зориулсан зээлийн хэмжээг 100 сая төгрөг болгож нэмэгдүүлэх; банкны хүүг бууруулах шийдлийг эрэлхийлэх. Банкны хүү одоогийн байдлаар жилд дунджаар 20-30 хувь байгаа нь бизнесийн хөгжлийн бүхий л боломжуудыг хааж байна.
- Боловсролын салбар: Эрэлт хэрэгцээтэй байгаа салбаруудад орон нутгийн иргэдэд зориулсан ажлын байр бий болгохын тулд мэргэжлийн боловсролыг дэмжих шаардлагатай; хүний хөгжлийг дэмжих чиглэлээр төрөл бүрийн чадавхи бэхжүүлэх сургалт явуулах; боловсролын чанарыг дээшлүүлэхэд анхаарах, чанартай цөөн боловсролын байгууллагатай болоход анхаарах
- Аялал жуулчлалын салбар: Масс аялал жуулчлал бус эко аялал жуулчлалыг Монголд хөгжүүлэх талаар судалгаа хийж, боломжийг судлах; ДБГ-ээс хөрөнгө оруулалтын санхүүжилт хийх замаар тус салбарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- Иргэдийн эрүүл мэндийг сайжруулах, эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулахад анхаарах.
- Усан хангамжийг сайжруулахын тулд Монголчууд мод их тарих хэрэгтэй

ДБГ-ийн стратеги ба түншлэлийн баримт бичигт тусгах санал	Салбарууд: <ul style="list-style-type: none"> • ДБГ нь Монгол улсад мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд голлон анхаарч дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. • Түүнчлэн байгаль орчныг хамгаалах, усны менежмент, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх / хамгаалахад ДБГ-ийн дэмжлэг туслалцаа төвлөрөх ёстой. • Мөн өсөлтийг дэмжиж, ажлын байр бий болгохын тулд хувийн хэвшил, бизнесийн орчинг дэмжвэл зохино.
--	--

Уулзалтын үеэр авсан судалгааны дүн:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Хувийн хэвшлийг хөгжүүлэх	4	44%
— Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	4	44%
— Худалдаа, экспорт	4	44%
• Боловсрол	3	33%
— Авилгатай тэмцэх	3	33%
— Байгалийн нөөцийн удирдлага	3	33%
— Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	3	33%
— Хүнсний аюулгүй байдал	3	33%
— Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	2	22%
— Хөдөөгийн хөгжил	2	22%
— Эрүүл мэнд	2	22%
— Эдийн засгийн өсөлт	2	22%
— Гадаадын хөрөнгө оруулалт	2	22%
• Төрийн удирдлага/шинэтлэл	1	11%
— Санхүүгийн зах зээл	1	11%
— Зам, тээвэр	1	11%
— Нийгмийн хамгаалал	1	11%
— Ус, ариун цэврийн байгууламж	1	11%
— Уур амьсгалын өөрчлөлт	1	11%
— Гамшгийн эрсдлийн удирдлага	0	0%
— Эрх тэгш боломжоор хангах	0	0%
— Хотын хөгжил	0	0%
— Эрчим хүч	0	0%
— Бусад	0	0%

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Хүний хөгжлийг дэмжих	5	56%
— Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	5	56%
— Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	4	44%

— Дээрх бүгд чухал	3	33%
— Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	2	22%
— Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	2	22%